



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 5/36

Хэрлэн сум

Ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.1.1, 40 дүгээр зүйлийн 40.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Галшар сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Н.Таня нь өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн тул 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн сургуулийн захирлын хөдөлмөрийн гэрээг цуцалж, үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

Хоёр. Сургуулийн захирлын ажлыг хүлээлцэх комисс томилон хүлээлцүүлэхийг сумын Засаг дарга/ Б.Энхтайван/-д даалгасугай.

Гурав. Н.Танятай зохих хууль, журмын дагуу холбогдох тооцоо хийж дуусгахыг сургуулийн нягтлан бодогч /Л.Оюунжаргал/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА